

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 01 ДҮГЭЭР САРЫН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**


2025 оны 02 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор байгууллагын үйл ажиллагааны 01 дүгээр сарын биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу төлөвлөгөөнд тусгагдсан 3 зорилтын 31 арга хэмжээг хамруулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Нийт арга хэмжээний 90.3 хувь нь үр дүнтэй буюу 100 хувь, 3.2 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувь, 6.5 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай буюу 50-30 хувьтай үнэлэгдлээ. (График 1, Хүснэгт 1)

График 1



Хүснэгт 1

Нийт арга хэмжээ	Арга хэмжээний зорилт, хэрэгжилтийн үнэлгээ /хувиар/						Хувь
	Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн		Эрчимжүүлэх шаардлагатай		Үр дүнгүй	Дундаж хувь
	100%	90%	70%	50%	30%	0%	
1	2	3	4	5	6	7	8
31	28	-	1	1	1	-	95.1

Зорилт тус бүрээр ангилан авч үзвэл Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна”, Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ” зорилтод тусгагдсан арга хэмжээнүүд бүгд ажлууд үр дүнтэй буюу 100 хувийн биелэлттэй бол Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд “Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна” зорилтын арга хэмжээнүүд эрчимжүүлэх шаардлагатай буюу 50 хувиар тус тус үнэлэгдсэн. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	50%	0-30%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна	3	-	-	1	1	1	50
2	Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна	7	7	-	-	-	-	100
3	Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ	21	21	-	-	-	-	100
Нийт		31	28	-	1	1	1	83.3

Чиглэл тус бүрээр авч үзвэл Мэдээллийн технологийн хэлтсийн төлөвлөсөн арга хэмжээнүүд үнэлгээ буурч эрчимжүүлэх шаардлагатай бол бусад нэгжийн төлөвлөн хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд бүрэн хэрэгжиж 100 хувиар үнэлэгдсэн. Үнэлгээ буурсан арга хэмжээнд:

-Мэдээллийн технологийн хэлтэс: гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70 хувийн гүйцэтгэлтэй -1, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй эрчимжүүлэх шаардлагатай буюу 50-30 хувийн гүйцэтгэлтэй-2 нийт 3 арга хэмжээ;

Хүснэгт 3

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	50%	30%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Захиргаа, удирдлагын газар	12	12	-	-	-	-	100
2	Виз, зөвшөөрлийн газар	2	2	-	-	-	-	100
3	Иргэний харьяаллын газар	1	1	-	-	-	-	100
4	Зөрчил шалган шийдвэрлэх газар	3	3	-	-	-	-	100
5	Санхүү, хангалт, үйлчилгээний газар	3	3	-	-	-	-	100
6	Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс	1	1	-	-	-	-	100
7	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс	2	2	-	-	-	-	100
8	Мэдээллийн технологийн хэлтэс	3	-	-	1	1	1	50
9	Зөвлөгөө, мэдээллийн хэлтэс	2	2	-	-	-	-	100

10	Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	1	-	-	-	-	100
11	Санхүүгийн хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	1	-	-	-	-	100
Нийт		31	28	-	1	1	1	95.4

Мөн газар хэлтсүүдийн буюу Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 1, Санхүү, хангалт, үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 1, нийт 2 арга хэмжээг хамтран гүйцэтгэсэн нь 100 хувь үнэлэгдсэн байна. Үүнд:

Дүгнэлт, зөвлөмж

Байгууллагын 2025 оны 01 дүгээр сард төлөвлөн гүйцэтгэсэн 31 арга хэмжээний хэрэгжилт 95.1 хувьтай үнэлэгдлээ. Цаашид дараах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай. Үүнд:

1. “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувьтай үнэлэгдсэн

Eimmigration.mn, ISM програмуудын хуучин датаг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (ISF)” систем рүү хөрвүүлэх (хэрэгжилт 70 хувь)

-Тус арга хэмжээг төлөвлөлтийн дагуу бүрэн хийж гүйцэтгэх нийт 7,713,118 мөр өгөгдлийг бүрэн шилжүүлж дуусгах шаардлагатай.

2. “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-50 хувьтай үнэлэгдсэн

“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системийг сайжруулах (хэрэгжилт 50 хувь)

“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (ISF)” болон цахим визийн систем (evisa)-ийн мэдээллийн сан хооронд өгөгдөл солилцох холболтыг хийж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх (хэрэгжилт 30 хувь)

-Дээрх 2 арга хэмжээг шалгуур үзүүлэлтэд тусгагдсан үйлчилгээний хөгжүүлэлтүүдийг хийж дуусгах, үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэх;

-Арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтод чиглэсэн хэрэгжилт, үр дүнг сайжруулахаар Мэдээллийн технологийн хэлтэс нь удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг нэмэгдүүлж ажиллах шаардлагатай.

3. “Үр дүнтэй” буюу 100 хувьтай үнэлэгдсэн 28 арга хэмжээний үр дүнг цаашид бууруулахгүйгээр чанаржуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.

--oo0oo--